



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/332/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Анализ старт аудит ХХК-ийн захирал Н.Энхтуяа Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com</p>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	2
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
СБД	Сүхбаатар дүүрэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-02-25 № 309
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. БАЯРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрүүл мэндийн төвийн “Салбар амбулатори”-ийн барилгыг дуусган 4,708.9 сая төгрөгийн өртгөөр санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллага нь 2025 онд ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын дагуу ЭМДЕГ-тай байгуулсан гэрээнд төлөвлөгөөт ангиллын тусламжийг сарын хуваариас хэтэрсэн тохиолдлын 20 хувиар хязгаарлалттайгаар санхүүжүүлж, цахим хасагдлаар 354.5 сая төгрөгийн орлогыг хассан байна.

Тус байгууллага нь ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын дагуу ЭМДЕГ-тай хийгдсэн гэрээнд төлөвлөгөөт ангиллын тусламжийг сарын хуваариас хэтэрсэн тохиолдлын 20 хувиар хязгаарлалттайгаар санхүүжүүлснээр тайлант онд цахим хасагдлагаар 354,466.2 мянган төгрөгийн орлогыг хасуулсан байна.

Бусад асуудал

Дүүргийн эх үүсвэрээр 2019 оноос эхлэн баригдсан "Сэлбэ нэгдсэн эмнэлэг"-ийн барилгыг Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11/64 дүгээр тогтоол, Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны А/417 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" захирамжийн дагуу ашиглалтад оруулж, 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Улсын комисс хүлээн авч, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн боловч барилгын гүйцэтгэлийн санхүүжилт дутуу шийдвэрлэгдсэн шалтгаанаар байгууллагын өмч бүртгэлд тусгаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,879,366,684.52</u>	<u>2,541,341,285.57</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,118,807,975.75	136,903,947.84
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,118,807,975.75	136,903,947.84
3121	Төгрөг	1,118,807,975.75	136,903,947.84
31211	Төрийн сангийн харилцах	1,118,807,975.75	136,903,947.84
33	АВЛАГА	2,244,680,042.64	1,085,741,962.83
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,186,791,542.64	1,028,165,462.83
335	Бусад авлага	57,888,500.00	57,576,500.00
3351	Байгууллагаас авах авлага	312,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	57,576,500.00	57,576,500.00
34	УРЬДЧИЛГАА	13,791,250.09	19,111,067.45
34600	Урьдчилж гарсан зардал	13,791,250.09	19,111,067.45
35	БАРАА МАТЕРИАЛ	1,502,087,416.04	1,299,584,307.45
351	Түүхий эд материал	1,133,426,249.03	1,005,807,157.27
35110	Тусгай зориулалттай материал	218,216,691.51	211,581,908.10
35130	Эм боох материал	915,209,557.52	794,225,249.17
354	Хангамжийн материал	368,661,167.01	293,777,150.18
35410	Бичиг хэргийн материал	41,738,364.50	5,386,720.00
35420	Аж ахуйн материал	6,666,794.98	4,784,018.00
35430	Сэлбэг хэрэгсэл	297,000.00	4,940,000.00
35440	Түлш, шатах тослох материал	329,555.20	345,714.65
35450	Барилгын засварын материал	12,948,850.00	-
35470	Бусад хангамжийн материал	306,680,602.33	278,320,697.53
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20,804,774,646.68</u>	<u>29,832,585,758.30</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,804,774,646.68	29,832,585,758.30
392	Биет хөрөнгө	20,620,502,206.68	29,648,313,318.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,340,110,307.49	16,135,915,238.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,115,971,881.33)	(1,305,203,599.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	451,612,000.00	425,422,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(151,812,000.10)	(159,852,000.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,105,041,281.28	20,468,975,279.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,196,414,534.99)	(6,950,644,882.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,501,016,106.94	1,528,877,281.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(352,819,653.89)	(528,692,721.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	84,094,557.20	60,250,739.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(48,587,365.92)	(30,967,405.80)
39217	Ном	4,233,390.00	4,233,390.00
393	Биет бус хөрөнгө	184,272,440.00	184,272,440.00
39301	Програм хангамж	11,894,494.95	11,894,494.95
39302	Хуримтлагдсан элэгдэл	(11,894,494.95)	(11,894,494.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	184,272,440.00	184,272,440.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>25,684,141,331.20</u>	<u>32,373,927,043.87</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>527,400,710.00</u>	<u>60,282,066.33</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	527,400,710.00	60,282,066.33

413	Өглөг	527,400,710.00	60,282,066.33
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	114,028.33
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	250,484,810.00	-
4136	Бусад өглөг	276,915,900.00	60,168,038.00
41361	Байгууллагад төлөх өглөг	276,915,900.00	60,168,038.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>25,156,740,621.20</u>	<u>32,313,644,977.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	25,156,740,621.20	32,313,644,977.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,960,126,433.81	1,960,126,433.81
51101	Өмч: - төрийн	1,960,126,433.81	1,960,126,433.81
512	Хуримтлагдсан үр дүн	17,837,387,752.76	24,995,533,309.10
51210	Өмнөх үеийн үр дүн	17,837,387,752.76	17,838,628,952.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	7,156,904,356.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,359,226,434.63	5,357,985,234.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>25,684,141,331.20</u>	<u>32,373,927,043.87</u>

2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	24,553,356,648.45	24,802,976,155.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,856,528,693.66	12,930,077,424.97
120	Нийтлэг татварын бус орлого	13,856,528,693.66	12,930,077,424.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,856,528,693.66	12,930,077,424.97
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	910,727,360.75	787,106,428.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	536,202,104.00	558,307,036.10
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,409,599,228.91	11,584,663,960.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,696,827,954.79	11,872,898,730.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	465,159,183.39	930,359,167.64
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	465,159,183.39	930,359,167.64
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,231,668,771.40	10,942,539,563.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,231,668,771.40	10,942,539,563.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,946,646,043.52	17,592,905,515.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,946,646,043.52	17,592,905,515.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,745,392,099.52	17,082,144,570.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,370,148,722.76	8,345,929,210.01
210101	Үндсэн цалин	3,757,421,814.45	4,644,791,973.88
210102	Нэмэгдэл	1,407,135,676.13	2,493,801,011.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	609,672,869.08	693,078,000.00
210104	Урамшуулал	595,918,363.10	514,258,225.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	844,394,061.97	1,006,224,889.58
210201	Тэтгэврийн даатгал	617,948,209.89	687,690,193.38
210202	Тэтгэмжийн даатгал	54,670,857.48	84,408,088.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,223,360.53	61,604,525.94
210204	Ажилгүйдлийн даатгал	26,685,515.93	34,123,220.75
210205	Эрүүл мэндийн даатгал	115,866,118.14	138,398,861.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	425,399,883.39	880,408,998.64

210301	Гэрэл, цахилгаан	84,168,258.76	237,999,866.93
210302	Түлш, халаалт	296,759,351.92	543,742,419.14
210303	Цэвэр, бохир ус	44,472,272.71	98,666,712.57
2104	Хангамж, бараа материалын зардал	780,862,775.54	587,708,268.29
210401	Бичиг хэрэг	76,326,016.00	93,246,014.50
210402	Тээвэр, шатахуун	12,399,148.30	19,109,223.19
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,474,106.65	28,458,547.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,331,770.00	26,741,964.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	212,221,044.00	188,228,443.69
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	94,774,455.97	-
210408	Бараа материал акалсны зардал	333,336,234.62	231,924,075.44
2105	Нормативт зардал	2,581,073,902.48	3,054,063,483.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,477,004,332.48	2,748,737,693.53
210502	Хоол, хүнс	47,629,570.00	270,147,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,440,000.00	35,178,490.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,111,485.00	126,668,059.00
210604	Урсгал засвар	70,111,485.00	126,668,059.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	579,140,700.50	446,456,351.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	546,936,520.00	386,124,328.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,500,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,410,000.00	4,088,168.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	305,428.00	1,411,348.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,500,000.00	44,760,386.10
210807	Газрын төлбөр	1,427,290.00	1,684,121.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,007,462.50	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,094,260,567.88	2,634,685,310.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,669,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,484,800.00	17,388,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,064,775,767.88	2,607,627,990.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,253,944.00	510,760,944.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	201,253,944.00	510,760,944.99
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	153,153,944.00	393,267,167.99
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,100,000.00	117,493,777.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,606,710,604.93	7,210,070,640.32
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	53,166,283.98
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	314,497,222.06	53,166,283.98
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-314,497,222.06	(53,166,283.98)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,292,213,382.87	7,156,904,356.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	11,248,513,272.90	14,381,589,674.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,490,856,964.75	1,350,064,864.10
120	Нийтлэг татварын бус орлого	1,490,856,964.75	1,350,064,864.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,490,856,964.75	1,350,064,864.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	955,499,360.75	791,757,828.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	535,357,604.00	558,307,036.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,757,656,308.15	13,031,524,810.45
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	465,159,183.39	930,359,167.64
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	465,159,183.39	930,359,167.64
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,292,497,124.76	12,101,165,642.81
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,292,497,124.76	12,101,165,642.81
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,187,784,172.17	14,189,708,427.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,187,784,172.17	14,189,708,427.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,986,530,228.17	13,678,947,482.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,380,690,840.36	8,376,063,771.26
210101	Үндсэн цалин	3,591,491,398.38	4,782,418,609.28
210102	Нэмэгдэл	1,566,334,044.17	2,410,456,659.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	607,118,567.13	668,579,291.20
210104	Урамшуулал	615,746,830.68	514,609,210.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	833,851,944.37	980,315,700.00
210201	Тэтгэврийн даатгал	595,551,844.37	655,022,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	82,074,700.00	81,323,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,037,500.00	40,661,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	26,037,500.00	40,661,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	104,150,400.00	162,646,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	425,399,883.39	880,408,998.64
210301	Гэрэл, цахилгаан	84,168,258.76	237,999,866.93
210302	Түлш, халаалт	296,759,351.92	543,742,419.14
210303	Цэвэр, бохир ус	44,472,272.71	98,666,712.57
2104	Хангамж, бараа материалын зардал	188,389,806.65	255,564,927.47
210401	Бичиг хэрэг	20,460,300.00	34,639,990.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	15,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,474,106.65	28,458,547.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	56,928,370.00	49,793,014.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	84,027,030.00	127,173,376.00
2105	Нормативт зардал	1,393,962,505.40	2,301,427,773.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,365,477,705.40	2,001,064,773.00
210502	Хоол, хүнс	28,067,000.00	266,445,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	417,800.00	33,918,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	129,348,750.00	157,044,709.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,454,050.00	40,189,200.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,192,000.00	11,260,600.00
210604	Урсгал засвар	70,702,700.00	105,594,909.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	556,110,418.00	682,920,593.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	512,938,440.00	610,641,328.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,500,000.00	9,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,410,000.00	4,088,168.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	305,428.00	503,931.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,500,000.00	45,510,386.10
210807	Газрын төлбөр	1,427,290.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,975,260.00	12,588,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,776,080.00	45,201,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	24,595,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,776,080.00	20,605,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,253,944.00	510,760,944.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	201,253,944.00	510,760,944.99
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	153,153,944.00	422,504,347.99
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,100,000.00	88,256,597.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,060,729,100.73</u>	<u>191,881,247.09</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	374,030,157.00	1,173,785,275.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	374,030,157.00	1,173,785,275.00
2200	Дотоод эх үүсвэрээр	374,030,157.00	1,173,785,275.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	374,030,157.00	1,173,785,275.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(374,030,157.00)</u>	<u>(1,173,785,275.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	686,698,943.73	(981,904,027.91)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	432,109,032.02	1,118,807,975.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,118,807,975.75	136,903,947.84

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,960,126,433.81	5,359,226,434.63	6,545,174,369.89	13,864,527,238.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,960,126,433.81	5,359,226,434.63	6,545,174,369.89	13,864,527,238.33
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	11,292,213,382.87	11,292,213,382.87
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,960,126,433.81	5,359,226,434.63	17,837,387,752.76	25,156,740,621.20

D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,960,126,433.81	5,359,226,434.63	17,837,387,752.76	25,156,740,621.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,241,200.00	1,241,200.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,960,126,433.81	5,359,226,434.63	17,838,628,952.76	25,157,981,821.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(1,241,200.00)	-	(1,241,200.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	7,156,904,356.34	7,156,904,356.34
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,960,126,433.81	5,357,985,234.63	24,995,533,309.10	32,313,644,977.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Ерөнхий данс		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Татаас, санхүүжилтийн орлого	13,261,513,767.64	13,031,524,810.45	229,988,957.19	98.3
	Улсын төсвөөс				
	Урсгал				
	Хөрөнгийн				
	Нөөц сангаас				
122005	Орон нутгийн төсвөөс	930,359,167.64	930,359,167.64		100.0
	Бусад төсөвт байгууллагаас				
	Нийгмийн даатгалын сангаас				
	Бусад тусгай зориулалтын сангаас				
122	Тусламжийн орлого	12,331,154,600.00	12,101,165,642.81	229,988,957.19	98.1
	Бараа, үйлчилгээний орлого	2,626,501,800.00	1,350,064,864.10	1,276,436,935.90	51.4
	Өмчийн орлого				
120	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	2,626,501,800.00	1,350,064,864.10	1,276,436,935.90	51.4
	Торгууль, төлбөрийн орлого				
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	15,888,015,567.64	14,381,589,674.55	229,988,957.19	90.5
	Ажиллагчидтай холбогдсон зардал	9,817,171,400.00	9,356,379,471.26	460,791,928.74	95.3
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	8,746,855,700.00	8,376,063,771.26	370,791,928.74	95.8
210101	Үндсэн цалин	5,232,838,200.00	4,782,418,609.28	450,419,590.72	91.4
210102	Нэмэгдэл	1,995,586,300.00	2,410,456,659.95	-414,870,359.95	120.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	610,850,600.00	668,579,291.20	-57,728,691.20	109.5

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	907,580,600.00	514,609,210.83	392,971,389.17	56.7
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	1,070,315,700.00	980,315,700.00	90,000,000.00	91.6
210201	Тэтгэврийн даатгал	745,022,900.00	655,022,900.00	90,000,000.00	87.9
210202	Тэтгэмжийн даатгал	81,323,200.00	81,323,200.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	40,661,600.00	40,661,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	40,661,600.00	40,661,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	162,646,400.00	162,646,400.00	-	100.0
210	Бараа, үйлчилгээний урсгал зардал	880,408,998.64	880,408,998.64	-	100.0
2103	Тогтмол зардал			-	
210301	Гэрэл цахилгааны зардал	237,999,866.93	237,999,866.93	-	100.0
210302	Түлш, халаалтын зардал	543,742,419.14	543,742,419.14	-	100.0
210303	Цэвэр, бохир усны зардал	98,666,712.57	98,666,712.57	-	100.0
2105	Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	2,097,138,000.00	2,267,509,773.00	-170,371,773.00	108.1
210502	Хоол	85,800,000.00	266,445,000.00	-180,645,000.00	310.5
210501	Эм	2,011,338,000.00	2,001,064,773.00	10,273,227.00	99.5
	Бусад бараа үйлчилгээний зардал	3,043,297,169.00	2,809,402,445.56	234,101,709.44	92.3
210401	Бичиг хэргийн материал	38,508,600.00	34,639,990.00	3,868,610.00	90.0
210402	Тээвэр, шатахууны зардал	37,153,300.00	15,500,000.00	21,653,300.00	41.7
210403	Шуудан холбооны зардал	30,000,000.00	28,458,547.47	1,541,452.53	94.9
210702	Дотоод томилолтын зардал				
210701	Гадаад томилолтын зардал				
210404	Ном, хэвлэлийн зардал				
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	23,000,000.00	20,605,500.00	2,394,500.00	89.6
	Сургалт семинарын зардал				
	Эрдэм шинжилгээний ажлын зардал				
210406	Жижиг эд хогшил худалдан авах зардал	130,000,000.00	127,173,376.00	2,826,624.00	97.8
210503	Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	33,937,500.00	33,918,000.00	19,500.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,500,000.00	9,500,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	5,910,000.00	4,088,168.00	1,821,832.00	69.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	539,700.00	503,931.00	35,769.00	93.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	373,000.00	88,000.00	285,000.00	23.6
	Харуул, хамгаалалтын зардал				
210808	Банкны үйлчилгээний хураамж	885,000.00		885,000.00	0.0
210801	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	620,443,200.00	610,641,328.00	9,801,872.00	98.4

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210809	Маягт хэвлүүлэх зардал	13,000,000.00	12,588,780.00	411,220.00	96.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	180,599,600.00	109,769,860.00	70,829,740.00	60.8
210602	Тавилга	20,000,000.00	6,600,000.00	13,400,000.00	33.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	12,000,000.00	11,260,600.00	739,400.00	93.8
210604	Урсгал зардал	1,214,950,169.00	1,203,199,524.00	11,750,645.00	99.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,119,400.00	24,595,510.00	4,730,876.00	84.5
	Байрны түрээсийн зардал				
210806	Холбооны суваг ашигласны зардал	54,493,300.00	45,510,386.10	8,982,913.90	83.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	434,384,400.00	422,504,347.99	11,880,052.01	97.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	154,500,000.00	88,256,597.00	66,243,403.00	57.1
210405	Бусад	50,000,000.00	49,793,014.00	206,986.00	99.6
	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	15,888,015,567.64	15,363,493,702.46	524,521,865.18	96.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,118,807,975.75	-	1,118,807,975.75
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		136,903,947.84	-136,903,947.84	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	287	265	22	92.3
620001	Удирдах ажилтан	2	2	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	211	189	22	89.6
620003	Үйлчлэх ажилтан	74	74	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	287	211	76	73.5
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	213	137	76	64.3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	74	74	0	100.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бараа материал, авлага данстай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Анализ старт аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудитор Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал Н.Энхтуяа, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын албаны аудитын менежер С.Гантөгс, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2026 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 13,261,143.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 132,611.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2 блок 5 давхар “Сэлбэ” эмнэлгийн барилгыг барьж, 2024 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсантай холбоотойгоор 2025 онд зардал өссөн учир материаллаг байдлыг шинэчлэн тогтоох, шаардлагатай учир шинэчилсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэрэг батлагдсан төсвийн зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын вэб хуудсыг хийлгэхээр байгуулсан 14,080.0 мянган төгрөгийн гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-нд дууссан. Гэвч СБД-ийн ЭМТ нэмэлт ажил хийлгүүлэхээр хүсэлт гаргасны дагуу хөгжүүлэлт хийгдэж, 2026 оны 1 дүгээр сарын 30-нд бүрэн хүлээн авч, акт үйлдэхээр тохиролцсон боловч гэрээний сунгалт хийгдээгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:40.1.1.захиалагч урьдчилан харах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах, гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд нэмэлт өөрчлөлтийг тусган баталгаажуулж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгнө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад мэдээллийг бүрэн байршуулсан байна..

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг аудитад хамруулж 10,068.0 мянган төгрөгийн 2 алдаа, 2 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар давтан үнэлж, 1,473.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1 зөрчлийг арилгасан байна. Залруулаагүй 8,595.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг жилийн эцсийн асуудлын бүртгэлд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар НББ-ийн бодлогын баримт бичгийг стандарт болон хуулийн өөрчлөлтийг тусган шинэчлэх талаар 1 зөвлөмж өгсөн.

НББ-ийн бодлогын баримт бичгийг шинэчлэн, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1		100.0
Нийт дүн	1		1		100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Харилцагч байгууллагуудтай өглөгийн үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлсэн акт үйлдсэн боловч И-баримтын системд байгаа нэхэмжлэхийн дүн санхүүгийн байдлын тайлан дахь өглөгийн дүнтэй таарахгүй байгааг анхаарах;

2. Хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй 74,668.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл акталсан байна. Дээд шатны байгууллагууд дотоод хяналт хэрэгжүүлж, эм вакцины хуваарилалтыг хэрэгцээ шаардлагад үндэслэн хуваарилах.

3. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батласан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг сайжруулахтай холбоотойгоор Сангийн яамны Finperform.mof.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах, дансны жишиг жагсаалтыг тус сайт дахь бүртгэлтэй тохируулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 53,885.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 22,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 31,385.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Тус байгууллага нь тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулах ёстой 22,500.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд гэрээ хийн худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно, 31 дүгээр зүйлийн 31.1."Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал дансанд 8,595.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. *Нягтлан бодох бүртгэлийн стандарт 4.1.3.Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт. 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4.үнэн зөв байх; 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;* гэж заасантай нийцэхгүй, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал дансанд бүртгэсэн 8,595.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг эрх бүхий байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэн дансны ангиллын дагуу бүртгэх.

2. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЭМДС-аас авах авлагаас 2025 онд эмчийн хасагдуулгаар 22,790.0 мянган төгрөгийн орлого хасагдсан нь, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх", 13.1.2-т "эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах", 13.1.4-д "даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх", 13.1-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмчийн хасагдуулгаар хасагдсан орлогыг өмнөх оны дүнгээс 20-иос доошгүй хувиар бууруулж ажиллах ажлыг зохион байгуулах, цаашид алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материал дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэгдсэн байна.	1	8,595.0					1	8,595.0				
Эмчийн хасагдуулга 22,790.0 мянган төгрөг байна.	1	22,790.0					1	22,790.0				
Тус байгууллага нь тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулах ёстой	1	22,500.0			1	22,500.0						

22,500.0 мянган төгрөгийн бараа материалыг шууд гэрээ хийн худалдан авсан												
Дүн	3	53,885.0			1	22,500.0	2	31,385.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Байгууллагын вэб хуудсыг хийлгэхээр байгуулсан гэрээ 2025 оны 12 дугаар сарын 31-нд дууссан. Гэвч СБД-ийн ЭМТ нэмэлт ажил хийлгүүлэхээр хүсэлт гаргасны дагуу хөгжүүлэлт хийгдэж, 2026 оны 1 дүгээр сарын 30-нд бүрэн хүлээн авч, акт үйлдэхээр тохиролцсон боловч гэрээний сунгалт хийгдээгүй байна.	1	14,080.0						1	14,080.0			
Дүн	1	14,080.0						1	14,080.0			



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 181/25025433

Улаанбаатар хот

НТАГ-2026/332/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэргээ. Үүнд:

Шууд гэрээгээр 22,500,000.00 (Хорин хоёр сая таван зуун мянган) төгрөгийн бараа материалыг худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна...", Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтын 1-д "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, харьцуулалтын аргаас зайлсхийж шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баярмаа/, Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны дарга /С.Шүрэнлхам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Н.ЭНХТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090457